



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ (Эрүүгийн хэрэг¹)

Гэмт хэрэг үйлдэхэд ашиглахаар завдсан техник хэрэгсэл гэдэгт төгсөөгүй гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан техник, хэрэгслийг хамтатган ойлгоно

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 2025/ХШТ/53

Шүүхийн шийдвэрийн огноо: 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Давж заалдах шатны шүүхийн магадлалын зарим хэсэгт өөрчлөлт оруулсан.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Шүүгдэгч Н.Н, Б.Ц нар бүлэглэн 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр Дорноговь аймгийн Сайхандулаан сумын нутаг дэвсгэрт өөрсдийн эзэмшлийн тоёота приус-10 тээврийн хэрэгслээр “Gold monster 1000” загварын металл хайгч, хүрз, зээтүү, малтуур зэргийг ашиглан тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлохыг завдсан гэх гэмт хэрэгт холбогджээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

- 1. Анхан шатны шүүхээс** шүүгдэгч Б.Ц-д холбогдох хэргийг “гэмт хэргийн “шинжгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, цагаатгаж, шүүгдэгч Н.Н-ыг тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмалын олборлолт явуулах гэмт хэрэгт бэлтгэсэн гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт² заасныг баримтлан 2000 нэгжтэй тэнцэх хэмжээний буюу 2,000,000 төгрөгөөр торгох ял шийтгэж уг ялыг 2 жил 6 сарын хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр тогтоож, Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэгт зааснаар “Gold Monster 1000” загварын металл хайгч болон өөрийн тээврийн хэрэгслийн үнэ 2,000,000 төгрөгийг гаргуулан улсын төсөвт оруулахаар шийдвэрлэсэн байна.

¹Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос:

https://shuukh.mn/single_case/3709?daterange=2025/01/01%20-%202025/05/28%20&id=3&court_cat=2&bb=1

²Эрүүгийн хууль(2015)-ийн 24.2 дугаар зүйл 1 дэх хэсэг “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар хууль бусаар газрын хэвлийд халдсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”.



2. **Давж заалдах шатны шүүхээс** анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 4 дэх заалтад “...2 жил 6 сар” гэснийг “...3 жил...” гэж, тогтоох хэсгийн 6, 7 дугаар заалтыг “... Gold Monster 1000 загварын металл хайгч, хүрз, зээтүү, малтуур зэргийг Н.Н-т, тоёота приус-10 загварын тээврийн хэрэгслийг Ц.Ц-д буцаан олгосугай” гэж тус тус өөрчилж, шийтгэх тогтоолын бусад заалтуудыг хэвээр үлдээж, прокурорын бичсэн эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэжээ.
3. **Прокурор хяналтын шатны шүүхэд бичсэн эсэргүүцэлдээ:** Эрүүгийн хэрэгт авагдсан гэрч Ц.Б, сэжигтэн Н.Н нарын мэдүүлэг тээврийн хэрэгсэлд үзлэг хийсэн тэмдэглэл, гэрэл зургийн үзүүлэлт, эд мөрийн баримтаар хураан авсан тэмдэглэл зэргээр шүүгдэгч Н.Н, Б.Ц нар нь тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмал олборлоход шууд чиглэсэн идэвхтэй үйлдэл хийсэн буюу Өмнөговь аймгаас Дорноговь аймгийг зорьж ирсэн боловч Цагдаагийн байгууллагын алба хаагчид хууль бус үйлдлийг таслан зогсоосны улмаас, тэдний хүсэл зоригоос үл хамаарах нөхцөл байдлаар гэмт хэрэг төгсөөгүй тул тусгай зөвшөөрөлгүйгээр хууль бусаар ашигт малтмалын олборлолтыг завдсан гэж үзнэ. Түүнчлэн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт гэмт хэрэг үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл нь бусдын өмчлөл болох нь тогтоогдсон тохиолдолд шүүх тусгай мэдлэг бүхий этгээдийн гаргасан үнэлгээг үндэслэн гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд ногдох хөрөнгөнөөс албадан гаргуулахаар зохицуулсан. Гэмт хэрэг үйлдэхэд ашигласан улсын дугаартай тээврийн хэрэгслийг 4,500,000 төгрөгөөр үнэлсэн шинжээчийн дүгнэлт гарсан байхад шүүх тус дүгнэлтийг шүүхийн шийдвэрийн үндэслэл болгожгүй, хуулиар олгогдоогүй үндэслэлээр тээврийн хэрэгслийн үнэлгээг 2,000,000 төгрөгөөр тогтоож үнийг гаргуулахаар шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Давж заалдах шатны шүүхээс гэмт хэрэгт бэлтгэх үйлдэлд техник хэрэгслийг хураах хууль зүйн үндэслэлгүй байна хэмээн тээврийн хэрэгслийн өмчлөгч болох Ц.Ц-д буцаан олгохоор шийдвэрлэж анхан шатны шүүхийн Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөнийг дүгнэлгүй байна...” гэжээ
4. **Хяналтын шатны шүүхээс** Хэргийн талаар хуульд заасан нотолбол зохих байдлуудыг хангалттай шалгаж тодруулсан, мөрдөн байцаалт болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хассан, хязгаарласан гэх зөрчил тогтоогдоогүй болно.
5. Анхан болон давж заалдах шатны шүүх хэрэгт цугларсан нотлох баримтад тулгуурлан шүүгдэгч Н.Н-ын дээрх үйлдлийг бодитой тогтоож, хууль бусаар ашигт малтмал олборлохыг завдсан бус уг гэмт хэрэгт бэлтгэсэн гэм буруутай гэсэн хууль зүйн дүгнэлт, шийдлийг гаргахдаа Эрүүгийн хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн байна. (19)
6. Гэмт хэрэгт бэлтгэх нь санаатай гэмт хэрэг үйлдэх эхний үе шат бөгөөд гэмт санаагаа бодитой хэрэгжүүлж, хүссэн үр дүндээ хүрэхэд тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн байна. Гэмт хэрэг үйлдэх дараагийн үе шат болох завдалт нь гэмт хэрэг үйлдэхэд чиглэсэн үйлдлээ хэрэгжүүлж, Эрүүгийн хуулиар хамгаалагдсан эрх ашигт бодитой халдлага, довтолгоо хийж эхэлсэн боловч өөрөөс шалтгаалахгүй хүчин зүйлийн улмаас таслан зогсоогдсон нөхцөл байдлыг



- ойлгох нь эрүүгийн эрх зүйн онол, хууль хэрэглээний жишигт нэгэнт тогтсон ойлголт юм.
7. Шүүгдэгч нь гар аргаар алт олборлох зорилгоор металл хайх зориулалттай техник, хүрз, зээтүү, малтуур зэрэг хэрэгслийг урьдчилан зэхэж, өөрийн тээврийн хэрэгслээр тухайн газарт очиж, “Алт гарч байгаа” гэх газрыг асууж сураглаж яваад цагдаагийн байгууллагад саатуулагдсан, газрын гадаргуу, түүний хэвлийд халдах оролдлого хийгээгүй байх тул уг үйлдэл нь Эрүүгийн хуулийн 2.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэмт хэрэгт бэлтгэх шатандаа таслан зогсоогдсон гэж үзэх хууль зүйн үндэслэлтэй байна. (22)³
 8. Харин давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлд заасан хөрөнгө, орлогыг хураах албадлагын арга хэмжээг хуулийн жинхэнэ агуулгаас нь зөрүүтэй тайлбарлан хэрэглэсэн байна. (26)
 9. Эрүүгийн хуулийн 7.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг ... албадан гаргуулна” гэж, 2 дахь хэсэгт “Гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж ... гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ойлгоно” гэж тус тус зааснаас үзвэл гэмт хэргийн замаар олсон хөрөнгө, орлогыг хураахын зэрэгцээ, гэмт хэрэг үйлдэхэд ашигласан техник, хэрэгслийг мөн адил хамааруулж хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгохоор зохицуулсан нь аливаа гэмт хэргээс хэн ч ашиг хүртэх ёсгүй гэсэн агуулга, үзэл санааг илэрхийлж байна. Гэтэл давж заалдах шатны шүүх “... ашиглахаар завдсан техник, хэрэгслийг ...” гэдгийг зөвхөн гэмт хэрэгт завдахдаа ашигласан техник, хэрэгсэл мэтээр явцуу хүрээнд тайлбарлажээ. (36)
 10. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 2.1 дүгээр зүйлийн 1, 2.7 дугаар зүйлийн 1, 2.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт гэмт хэргийн ойлголт, шинжийг тодорхойлохдоо бэлтгэх, завдах, төгс үйлдэх бүх үе шатыг хамааруулан хуульчилж, эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зааснаас үзвэл гэмт хэрэг үйлдэхэд ашиглахаар завдсан техник, хэрэгсэл гэдэгт төгсөөгүй гэмт хэрэгт бэлтгэх, завдахад ашигласан техник, хэрэгсэл гэж ойлговол зохино. (38)
 11. Шүүгдэгч Н.Н тоёота приус-10 загварын улсын дугаартай тээврийн хэрэгслийг ашигт малтмал олборлох зориулалтаар тусгайлан бэлтгэсэн гэж шууд дүгнэх боломжгүйгээс гадна ердийн зориулалт бүхий тээврийн хэрэгслийг хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг үйлдэхэд ашигласан, эсхүл ашиглахаар завдсан гэж үзэх нөхцөл байдал тогтоогдоогүй тул тээврийн хэрэгслийн үнийг шүүгдэгчээс гаргуулахаар шийдвэрлэснийг хүчингүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалын холбогдох заалтыг хэвээр үлдээхээр шийдвэрлэжээ. (41)
 12. Иймд прокурорын эсэргүүцлийн зарим хэсгийг хангаж, шүүгдэгч Н.Н-ын гэмт хэрэг үйлдэхэд бэлтгэсэн металл хайгч “Gold Monster 1000” загварын багаж, хүрз, зээтүү, малтуур зэргийг буцаан олгохоор заасан магадлалын холбогдох хэсгийг хүчингүй болгож шийдвэрлэсэн байна. (39)

³ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн шийдвэрийн цогцолборын дугаар болно.”



---o0o---